

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Цэнд	Дугаар	Л117
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Мөрөн
Төрсөн газар	Мөрөн	Төрсөн он	
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Гичгэний хурал	Сүм хийдийн дугаар	ХЭЖХ 011
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 30	Ярилцлага авсан хүн	Ч.Хулан



Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Гичгиний хийд

-Та Гичгиний хийдийн тухай ярьж өгөөч?

Би Гичгэний хийдийн түүрин дээр суварга босгосон. Лхам гэдэг хүн байсан. Насаараа багийн дарга байсан. Тэр хүний хоёр хүүхэд Сүхбаатар Мягмар гэдэг хоёр хүн, Миний хоёр хүү Батболд, Баярсайхан хоёр, Чойжоо, Миний дүү Жамъянсүрэн гэж орно. Хотод байдаг. Энэ хүмүүсийн санаачлага зүтгэлээр суварга босгосон.

-Мөрөнд харъяалагдсан Замбалин хийд гээд. Жаргалтхаан Мөрөн хоёрын зааг дээр Нарийн овоо гэдэг газар. Таны өссөн газар хийд байсан уу?

Байсан. Нарийнаас баруун тийш байсан. Балгас чулуу нь ч байсан. Тэрүүнийг цааш нь Гичгэний хийдтэй нэгтгэсэн гэж байсан. Чухам хэдэн онд нэгтгэснийг нь мэдэхгүй. Завилай Ерэнтий гэдгийг чинь л Гичгэнэд нэгтгэсэн гэж байсан. Гичгэнээс зүүхэн хойт дээгүүр чинь нэг ухаа даваад л чулуунууд байгаа. Тэр чинь нэг жижигхэн юм байсан юм шиг байгаа юм. Нэг жижигхэн юм байсан юм шиг байгаа юм.

-Тэр хавьд Мандал толгой гэж байна уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Байгаа. Улаан ганганы энүүхний чинь Мандал толгой гэдэг. Мандал толгойн өвөрт байгаа. 1932 онд хэлмэгдүүлээд устгачихсан. 1932 онд миний эмэг эхийн эцгийг цаазалсан юм. Гомбожав гэж хүн байсан. Тэргүүн лам Гомбожав гэж байсан.

-Нарийний хийдийг өөрөөр хоёр нэрээр нэрлэдэг байсан юм шиг байна лээ. Замбилин нөгөө хэсэг Дандалин ч гэдэг байсан юм шиг байна лээ.

Замбилан хийд гэж байсан юм гэнэ лээ. Урьд яасан их завилдаг эр вэ гэхэд нь Завилж суух нь заяаны суудал, Оцойж суух нь нохойн суудал юм гэж хэлж байсан гэдэг. Завилаа отог гэж болсон.